

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 6 ДУГААР
САРЫН 23-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-13
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	14-66
	1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, /эцсийн хэлэлцүүлэг/	14-65
	2.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмчилгээ, эмнэл зүй, тархвар судлалын талаар Эрүүл мэндийн сайд болон Улсын онцгой комиссын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн мэдээлэл сонсох	65-66

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 23-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Байнгын хорооны хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэг, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ц.Мөнх-Оргил, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нар “Их эзэн Чингис хаан” танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан Байнгын хорооны хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 12 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 75.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Жаргалмаа.

Нэг.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Г.Адъяа, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч О.Амартүвшин нар “Их эзэн Чингис хаан” танхимаас, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ш.Маяа нар цахимаар тус тус оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн хэлтсийн референт Б.Мажигсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал:

М.Оюунчимэг: 1.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “хамтын сонирхлын маргааныг” гэснийг “хамтын сонирхлын маргаан эсхүл энэ хуулийн 25.2-т заасан хөдөлмөрийн эрхийн маргааныг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн Хөдөлмөрийн эрхийн маргааныг бусад заалтуудтай нийцүүлэн дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.16.Хөдөлмөрийн эрхийн маргаан гэж хөдөлмөрийн хууль тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хэрэгжүүлэх, эсхүл эдгээр хэм хэмжээг тайлбарлахтай холбоотойгоор талуудын хооронд үүссэн саналын зөрүүг” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 11 дүгээр зүйлд “ажилтны төлөөлөгчид”-ийн дараа “ажилтан” гэдэг гол үгийг орхигдуулсан тул дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “ажилтны төлөөлөгчид” гэсний өмнө “ажилтан” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “ажил олгогч” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 30 дугаар 30.2 дахь хэсгийг өөрчлөн дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “сонирхлын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан, “Ажил олгогч нь ажилтныг мэргэжлээ дээшлүүлэх, давтан сургах боломжоор хангах үүргийг” гэснийг “ажлын байрны чиг үүргийн дагуу” гэж тодотгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 2

Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалтын “хууль тогтоомжид заасны дагуу” гэсний дараа “ажлын байрны чиг үүрэгт хамаарах чиглэлээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн төслийн бусад заалттай нийцүүлж “нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг ажил олгогч болон даатгуулагчаас төлөх” гэсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсгийн “Дагалдангаар суралцах ажилтны” гэсний дараа “ажил олгогчоос болон ажилтнаас төлөх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт давхардсан утга бүхий үг хасах засвар хийсэн тул саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн найруулгын шинжтэй саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “үйлчлэх хугацаа” гэсний дараа “хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15

86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан, 79.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 80 дугаар зүйл дээр техникийн шинжтэй засвар хийсэн тул дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг” гэсний дараа “энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 83.3 дахь хэсэгт заасан “ажил олгогч ажлаа хүлээлгэн өгөх хугацаа хүртэл” гэж тодорхой заах гэсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 1
Бүгд: 15
93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83.5.Ажилтанд энэ хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт заасан хугацааны цалин хөлсийг ажил олгогч тооцож олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 12 дугаар зүйл дээр техникийн шинжтэй засвар хийсэн тул дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсгийн “ажлын байранд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсгийг өөрчлөн найруулсан тул саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“92.5.Энэ хуулийн 92.4-т заасан хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 14 дэх саналыг техникийн шинжтэй засвар орсон тул дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 104 дүгээр зүйлийн 104.7 дахь хэсгийн “олгоогүй, эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 15 дахь саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 107 дугаар зүйлийн 107.2 дахь хэсгийн “хамтын хэлэлцээрээр зохицуулна.” гэснийг “хамтын хэлэлцээрээр зохицуулж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 123 дугаар зүйл дээр давхацсан агуулга бүхий өгүүлбэрийг хассан тул дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 123 дугаар зүйлийн 123.7 дахь хэсгийн “Ажил олгогч, сахилгын зөрчлийн шинж, үр дагаврыг харгалзан энэ хуулийн 114.1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэнэ.” гэсэн хоёр дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 123 дугаар зүйлийн 123.7 дахь хэсгийг дахин санал хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 154 дүгээр зүйлийн 154.11 дэх хэсгийн “эсхүл шийдвэрийг” гэснийг “эсхүл шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш” гэж өөрчилж мөн хэсгийн “хүлээн авснаас хойш” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх хугацааг 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөх гэснийг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 166 дугаар зүйлийн 166.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“166.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Хөдөлмөрийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл нарын гаргасан, Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсгийн “ажлын 20 өдөр” гэснийг “ажлын 15 өдөр” гэсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсгийн “ажлын 20 өдөр” гэснийг “ажлын 15 өдөр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил санал хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

М.Оюунчимэг: Төслийн 99.4, 99.6 дахь хэсгийг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

М.Оюунчимэг: Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “Төрийн албан хаагчид олгох, ээлжийн нэмэгдэл амралт” гэсэн 61¹ дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил санал хэлэв.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	0
Бүгд:	14

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу “Хөдөлмөрийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил “Хөдөлмөрийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргав.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

М.Оюунчимэг: “Хөдөлмөрийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
-------------	----

Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргав.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

М.Оюунчимэг: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Төслийн талаар Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргав.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

М.Оюунчимэг: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4

Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргав.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

М.Оюунчимэг: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргав.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

М.Оюунчимэг: Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргав.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэх гэж байгаатай холбогдуулан “Оюу толгой” ХХК-аас ирүүлсэн саналыг уншиж танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 6 ДУГААР
САРЫН 23-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

М.Оюунчимэг: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 69 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанд гишүүд танхимаар болоод цахимаар оролцож байна. Улсын Их Хурлын гишүүн Анужин, Батлут, Бейсен, С.Ганбаатар, Жаргалмаа, Сандаг-Очир, Сарангэрэл, Саранчимэг нарын гишүүд цахимаар оролцож байна. Танхимаар Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил, Чинбүрэн, Чинзориг нарын гишүүд танхимаар оролцож байна. Тасалсан болоод чөлөөтэй гишүүд алга байна. Одонтуяа гишүүн, Туваан гишүүн цахимаар ирцэндээ одоо орж байгаа юм байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг өнөөдөр хийхээр байгаа.

Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол, Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

2.Хэлэлцэх хоёр дахь асуудал маань Коронавируст халдвар, КОВИД-ын эмчилгээ, эмнэл зүй, тархвар судлалын талаар Эрүүл мэндийн сайдын болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга нарын мэдээллийг сонсохоор байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Цахимаар байна уу? Алга байна.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал нэг

Нэг.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүд та бүхэнд бүгдэд нь тараасан байгаа. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Цэндийн Мөнх-Оргил гишүүн танилцуулна.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн чуулганаар анхны хэлэлцүүлгийг 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаан даргалагчаас төслийн зарим зүйл, заалт, хэсэг, заалтыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулах чиглэл өгсний дагуу уртын ээлжээр ажиллах 14, 14 хоногийн хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцох, үл өрсөлдөх гэрээний үйлчлэх хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дууссанаас хойш нэг жилээс илүүгүй байх, ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглох зэрэг зарчмын зөрүүтэй саналуудыг бэлдлээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу ажил хаялт, хөдөлмөрийн эрхийн маргаан, гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээг тодорхой болгож, ажил олгогч, ажилтныг хууль тогтоомжид заасны дагуу ажлын байрны чиг үүргийн дагуу мэргэжлээ дээшлүүлэх, давтан сурах боломжоор хангах, дагалдангаас суралцах ажилтны ажил олгогчоос болон ажилтнаас төлөх, нийгмийн даатгалын шимтгэлийг тодорхой болгох, мөн хуулийн төслийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх зэрэг зарчмын зөрүүтэй 16 санал бэлтгэлээ. Эдгээр 6 саналын 6 санал нь Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын бэлдэж, ажлын хэсэгт ирүүлсэн санал болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасны дагуу “Хууль, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

Хөдөлмөрийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүнд баярлалаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Цахимаар хоёр гишүүн байна. Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Б.Энхбаяр гэсэн хоёр гишүүн цахимаар асуулт асуухаар нэрээ өгсөн байна. Сарангэрэл гишүүнийг урьж байна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Хөдөлмөрийн хууль дээр ажилласан ажлын хэсгийнхэнд талархаж байгаа. Манай Мөнх-Оргил гишүүн бас аргагүй туршлагатай гишүүний хувьд бол энэ хууль дээр их сайн ажилласан гэдгийг хөндлөнгөөс хараад үнэлж, талархаж байгаа.

Асуулт болон хэд хэдэн тодруулах зүйл бол байна. Ажилласан жилийг харгалзахгүйгээр амралтын өдрийг 20 хувь болгосон нь бол би энийг зөв зүйтэй гэж бодохгүй байгаа юм. Яагаад гэвэл юу хуучин бол ер нь амралт маань 15 хоногоос эхэлдэг, 5 жил тутамд 3 хоног нэмж олгодог. Энэ нь өөрөө тухайн хүн ажлын байрандаа тогтвортой ажиллах. Тэгээд мэдээж тэр хүний нас нэмэгдэж байгаатай холбогдуулан бас ажил амралтаа зохицуулах ийм шаардлага байдаг. Энэ бол бас нэлээд тийм судалгаа, шинжлэх ухааны үндэслэлтэй хийсэн энэ амралтын хугацааг бол зүгээр л ажилласан жилийг үл харгалзан шууд 20 хоног болгож байгааг бол, би энийг оновчгүй гэж үзэж байгаа. Энийг та нар ямар үндэслэлээр ийм өөрчлөлт хийж байгаа юм бэ? Энийгээ нэг хэлээч гэж.

Хоёрдугаарт, уурхайчдын тухайд 28 хоног ажиллаад 10-14 хоног амардаг бол энэ бол гэр бүлд бол үнэхээр сөрөг байсан. Үүнийг 14 хоногийн амралт 14 хоногийн хугацаатай ажил эрхлэх ийм боломжийг олгож байгаад, үнэхээр манай ажлын хэсэг бол зөв шийдэл байлаа гэж ингэж үзэж байгаа. Тэгээд хөдөлмөрийн гэрээг тодорхой болгоно, байнгын ажлын байр гэж юу хэлэх вэ?

Энэ талын мэдээллүүдийг, яг хуулийн төсөлтэй ингээд уншаад танилцахад жоохон ойлгогдохгүй байна лээ. Энэ хөдөлмөрийн гэрээг тодорхой болгох асуудлынхаа талаар иргэддээ бас мэдээлэл өгөх нь би зүйтэй гэж ингэж бодож байна.

Дөрөвдүгээрт хэлэх гэж байгаа зүйл бол ажлын байрны дарамт, хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд учрах янз бүрийн бэрхшээлүүд байгаа. Дээр нь бидний сүүлийн үед маш их ярьж байгаа бэлгийн дарамт. Энэ их тодорхойгүй орсон гэж бодогдлоо Мөнх-Оргил гишүүн ээ? Ерөнхийдөө ингээд хөдөлмөрийн харилцаанд ажлын байран дахь дарамт, энэ элдэв юм, бэлгийн хүчирхийллийг хориглоё гээд. Энэ тодорхойгүй байна. Гадаад орны туршлагауд байж байгаа шүү дээ. Ерөөсөө аж ахуйн нэгжүүд ажлын байранд нөгөө ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн харилцаанд баримтлах зарчим, дүрэм гэдгийг байгууллага болгон ингэж гаргаж мөрдөнө.

М.Оюунчимэг: Сарангэрл гишүүн 1 минут нэмж авах уу? Хариултын дараа авах уу? Хариултаас өмнө ажлын хэсгийг танилцуулъя. Танхимд биечлэн оролцож байгаагаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн дарга Өнөрбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Алимаа, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Ганбаатар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Адъяа, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Амартүвшин гэсэн нарын хүмүүс танхимаар оролцож байна. Цахимаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Ариунзаяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Маяа гээд ийм хүмүүст оролцож байгаа.

Мөнх-Оргил гишүүн хариулъя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Жилийн ээлжийн амралтын хугацааг ажилласан жилээс нь шалтгаалаад нэмэлт өдрүүдтэй ажлын 15 хоног буцаагаад болгоё гэдэг саналыг Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир өнгөрсөн ажлын хэсгийн хуралдаан дээр гаргасан. Тэгээд өнөөдөр энэ асуудлаар санал хураана. Манай ажлын хэсэг энэ саналыг дэмжихэд бэлэн байгаа. Тэгэхдээ санал нь бол Сандаг-Очир гишүүнээс орж ирнэ. Хэрвээ та хүсвэл энэ санал дээр хамтран санал оруулж болно. Яагаад 15, 20 болгосон энэ тэр гээд янз бүрийн үндэслэлүүд бол байгаа. Тэгэхдээ нэгэнт одоо буцаад 15-даа орж байгаа учраас энэ үндэслэлүүдийг дэлгэрүүлж тайлбарлаж яриад яах вэ?

14 хоног ажиллаад 14 хоног амардаг тогтолцоонд уртын ээлжийнхэн шилжинэ. Энэ хуулиар гэхдээ тодотгол оруулж өгсөн 14-өөс доош хоног ажиллахаар бол 14-өөс яг тэр ажиллаж байгаа өдөртөө тэнцсэн өдөр амрахаар тохиролцож болно гэдэг заалт тодотгож өгч байгаа юм. Яагаад гэвэл орон нутгийн олон уурхайнууд 7, 7 хоногоор ажиллаж амардаг юм байна. Тэгэхээр хуулиараа бид нар бүгдийг нь 14 гээд хатуу заачихаар, бас зарим жижиг ялангуяа уурхайнуудын ажилд хүндрэлтэй юм байна гэж үзсэн.

Байнгын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг тодорхой болгох асуудлуудыг бол энэ хуульд нэлээн дэлгэрүүлж оруулсан. Бид нар хуулиа сурталчлаад тайлбарлаад явахад бол энэ гарсан ахицууд олон түмэнд илүү ойлгомжтой болох байх гэж бодож байна. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох асуудлаар өргөн барьсан хуулийн төсөлд ч тодорхой туссан. Ажлын хэсгээс шинэчилсэн найруулга дээр ажиллаж байх явцдаа ч гэсэн энийг нэлээн дэлгэрүүлж задалсан.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргилд 1 минут нэмж өгье.

Ц.Мөнх-Оргил: 7 дугаар зүйл, өөрөөр хэлбэл, хуулийн төсөл дөнгөж эхлэнгүүт л 7 дахь зүйл гэдэг бол нэлээн тийм ач холбогдол, өгсөн чухал заалт болгож оруулж байна гэсэн үг. 7 дугаар зүйл нь ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглоно гээд. Тэгээд энэ дарамт гэдгийг тодорхойлсон хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах, хүчирхийлэл гэдэг нь зодох, цохих зэргээр бусдын эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр заналхийлэх, бэлгийн дарамтыг хориглож байгаа нь бол бэлгийн дарамтыг тодорхойлохдоо ажил, эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээр, үгээр, биеэр, цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн харилцаанд орох эсэхээс шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар урамшуулах, эсвэл хохироохоор айлган сүрдүүлэх тулган шаардах, болзол тавих байдлаар бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно гээд тодорхойлолтуудыг нэлээн.

М.Оюунчимэг: Сарангэрэл гишүүн 1 минут нэмж тодруулъя.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Тэгээд ер нь Мөнх-Оргил гишүүн, энэ ажлын байрны бэлгийн дарамт шахалт хүчирхийлэл, энэ дарамтын талаар бол бид нар их ярьж байгаа. Тэгээд энэ болгон бол хуулиар ингээд зохицуулагдаад хуульд заагаад явж байгаа боловч амьдрал дээр ерөөсөө хэрэгжихгүй байгаа учраас энийг ингээд бусад орны гадаадын туршлага илүү их ажлын байранд тулгуурласан тухайн байгууллагын дүрэм, журам байхаар, тэрийг ажилтнуудад нь маш сайн ойлгуулсан. Ялангуяа тэр албаны эрх нөлөөний хүмүүст их ойлгуулсан ийм зүйлийг энэ хуулийг хэрэгжүүлэх журам дээр анхаарч ажиллах ёстой юм байна гэж ингэж бодож байгаа.

Би тэгээд Сандаг-Очир гишүүнтэй тэр амралтын хоног дээр бас санал нэгдэж оръё гэдгийг хэлье. Дээр нь энэ хуулийн төсөлд та бүхний маань оруулсан бас нэг гол зүйл бол хүний бичиг баримтыг барьцаалдаг нэг тийм эвгүй, сэтгэлд их таагүй тэр зүйлийг бол бас үгүй болгож байгаа юм байна лээ. Үүнд талархаж байгаа шүү. Тэгээд би ч гэсэн манай Нийгмийн бодлогын байнгын хороо, дарга Оюунчимэг, ажлын хэсгийн дарга Мөнх-Оргил гишүүн, үйлдвэрчний байгууллага, Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хөдөлмөрийн яам энэ байгууллагууддаа, та бүхэндээ маш их талархаж байгаа шүү. Би бас парламентад.

М.Оюунчимэг: Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Юуны урьд олон парламент, Засгийн газар дамнаж яригдаж байсан, одоо хамгийн суурь хууль. Энэ хуулийн өөрчлөлт хамаарахгүй нэг ч хүн байхгүй том байхгүй. Тэгээд ийм суурь хуулийг бас гаргаж, энэ парламентын үед энэ том шинэтгэлийг хийж байгаа Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн бодлогын байнгын хороо,

ажлын хэсэг Мөнх-Оргил гишүүн, мөн ажлын хэсгийн бүх гишүүдэд бас талархал илэрхийлье.

Энэ Хөдөлмөрийн хуулийг дагасан эрүү, зөрчлийн хууль явж байсан. Би тэр дотор манай Хууль зүйн байнгын хороо ярина гээд орхичихсон байсан. Тэр чинь хэвээрээ байна уу? Одоо ингээд энэ чинь эцсийн хэлэлцүүлэг гэхээр ингээд батлагдчихаж байна уу? Тэр гаргасан хуулиуд яах билээ? Тэр дотор чинь ажлын байрны бэлгийн дарамтаас эхлүүлээд эрүү, зөрчлийн хуульд орох өөрчлөлтүүд чинь тэнд яваад байсан байхгүй юу. Тэгээд би тэр асуудал орхигдож байна уу, эсвэл одоо ингээд цуг батлагдчихаж байна уу гэдэг асуулт байна. Баярлалаа.

М.Оюунчимэг: Энхбаяр гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүн хариулъя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газар өргөн барихдаа нийт 19 хууль хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн барьсан юм. Тэгээд эд нарыг бол ихэнхийг нь бид нар анхны хэлэлцүүлгээрээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаараа оруулчихсан. Гэхдээ энд хоёр, гурван хууль үлдчихээд байгаа юм. Нэгдүгээрт ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой Эрүүгийн хуульд нэмэлт орох ёстой. Мөн Хөдөлмөрийн хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбогдуулж торгууль ногдуулах асуудлууд Зөрчлийн хуульд орох ёстой. Тэгээд энэ хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, ажил үүрэг, гүйцэтгэх гэрээ гээд Иргэний хуулийн гурван төрлийн гэрээний тодорхойлолтуудыг шинэчлэх шаардлага байгаа.

Ингээд энэ гурван хуулийг бид нар хэлэлцүүлэе гэдэг байр суурьтай байж байтал Их Хурлын Тамгын газрын хуулийн хэлтсийнхэн, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамныхан хуульд тэртээ тэргүй 2022 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр болох юм байна. Тэр хооронд Засгийн газар, Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барина, энэндээ танай энэ саналуудыг бүгдийг нь суулгаад нэмээд оруулчихъя. Эрүүгийн хуульд зарим засвар өөрчлөлт оруулах асуудлууд орно, тэр дотроо энэ саналуудыг нэмээд оруулчихъя. Тэгээд намрын чуулганаар өргөн барья гэдэг санал тавьсан.

Тэгээд бид саналыг нь хүлээж аваад одоо хууль батлагдаад хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хүртэлх хугацаанд Засгийн газар Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найруулгад нийцүүлэн Эрүүгийн, Иргэний, Зөрчлийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, Эх, олон хүүхэдтэй эх, өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай эдгээр хуулиудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг 2021 нэгэн оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлээч ээ. Мөн Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлээч ээ гэсэн үүргийг Засгийн газарт даалгаж байгаа.

М.Оюунчимэг: Энхбаяр гишүүн 1 минь тодотгоё.

Б.Энхбаяр: Одоо энэ танхимд Засгийн газрын сайдаас хэн байгаа юм бол, энд шууд амыг нь авмаар байна. Засгийн газар чинь ерөөсөө хуулийн төсөл барихдаа маргааш, маргааш, маргааш гээд л маш олон юман дээр тэгээд байгаа шүү дээ. Төрийн өмчийн багц хуулийг 2020 оны намрын чуулган байсан, одоо 2021 оны намар гэсэн юм ярьчихсан л байж байна. Тэгээд сүүлд нь Их Хурал өөрөө

батлаагүй орхичихсон юм шиг, ажлын хэсэг хойшлуулчихсан юм шиг ярьж болохгүй. Би протоколд үлдээхийн тулд. Засгийн газар та нар өөрсдөө тэгвэл хэлсэн байна шүү, намар өргөн барина гэж хэлсэн байна. Тэрийг нь бас протоколд үлдээчихмээр байна. Сайд нараас хэн нь байгаа юм бол?

М.Оюунчимэг: Ариунзаяа сайд байна уу? Цахимаар Ариунтуяа сайд оролцож байгаа. Ариунзаяа сайд сая Энхбаяр гишүүн бас протоколд тэмдэглүүлье гэсэн байна. Энхбаяр гишүүнтэй зарим зүйл дээр бас санал нэг байна. Чухал санал хэлж байна. Ариунзаяа сайд саналаа хэл дээ. Сая Энхбаяр гишүүний хэлсэн үгийг сонссон уу? Саналаа хэл дээ.

А.Ариунзаяа: Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Энхбаяр гишүүнд одоо амлаад хэлэхэд бид үйлдвэрчний эвлэлтэй хамтраад Үйлдвэрчний эвлэлийн хуулийг энэ намартаа өргөн барихаар энэ зунжингаа ажиллая. Баярлалаа.

М.Оюунчимэг: Засгийн газрын гишүүд анхааралдаа авна шүү дээ. Одоо цахимаар оролцож байгаа гишүүддээ тоног төхөөрөмжөө бэлдээрэй санал хураалт одоо ингээд явах гэж байна шүү гэдгээ хэлье.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахаар байгаа. Энэ анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгээс саналын зарим хэсэг, заалтыг өөрчлөн найруулах, үг нэмэх хасах шаардлага үүссэн гэж үзсэн учир Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу эцсийн хэлэлцүүлэгт тухайн саналуудыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дахин хураалгах нь зүйтэй гэж дэмжсэний дараа энгийн горимоор тухайн зарчмын зөрүүтэй саналыг хураалгахаар байгаа. Тийм учраас гишүүд маань санал хураалтын үед маш анхааралтай байгаарай гэж хэлэх байна.

Ингээд гуравны хоёроор батлаад, дэмжигдсэн тохиолдолд энгийн горимоороо санал хураалт явагдана. Гэхдээ олон санал биш байгаа. Гишүүддээ хэлэхэд энэ 18 санал байгаа юм байна. Гишүүд бэлэн үү, эхлээд туршилтаар яваад үзэх үү?

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа 13 гишүүний 9 нь дэмжиж байж энэ маань өөрөө босно шүү гэдгийг манай гишүүд сайн анхаараарай. Эхлээд нэг туршилтын санал хураалт явуулъя.

1. Ажлын хэсгийн хурал дээр бусад заалтуудтай нийцүүлэн ажил хаялтыг дахиж тодорхойлохоор болсон байгаа. Үүнтэй холбогдуулаад анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэснийг дэмжье гэсэн горимоор санал хураалт явуулъя. Хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дэмжих ёстой байгаа. Туршилтын санал хураалт.

Энэ бүртгэлийн санал хураалт байгаа. Чинзориг гишүүний аппарат нь болоогүй байна. Саранчимэг гишүүн, Жаргалмаа гишүүн, Бейсен, Батлут гишүүд маань ирцдээ орчихсон байгаа. Санал хураалтдаа идэвхтэй оролцоорой. Бүртгэлийн санал хураалт сая явсан.

Одоо жинхэнэ санал хураалт.

1.Ажлын хэсгийн хурал дээр бусад заалтуудтай нийцүүлэн ажил хаялтыг дахиж тодорхойлохоор болсон байгаа. Үүнтэй холбогдуулаад анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг дахин хураалгах нь зүйтэй гэснийг дэмжье гэсэн горимоор санал хураалт.

Гишүүдээ, дэмжье гэсэн горимоор.

14 гишүүн оролцсоноос 12 дэмжиж, 85.7 хувиар энийг дэмжих нь зүйтэй гэж үзсэн байна. Ингээд одоо энгийн горимоор санал хураалт

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын хамтын сонирхлын маргааныг гэснийг хамтын сонирхлын маргаан эсхүл энэ хуулийн 25.2-т заасан хөдөлмөрийн эрхийн маргааныг гэж өөрчлөх.

Санал хураалт, гишүүд ээ. Дэмжье гэсэн горимоор санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 12 дэмжиж, 80 хувиар дэмжигдлээ. Гишүүддээ баярлалаа.

2.Хөдөлмөрийн эрхийн маргааныг бусад заалтуудтай нийцүүлэн дахиж томъёолон санал хураахаар ажлын хэсэг дээр ярьсан байгаа. Үүнтэй холбогдуулаад санал хураалтыг дахин явуулъя. Үүнийг дэмжье гэдгээр санал хураалт. Гуравны хоёр нь дэмжих ёстой.

Санал хураалт, гишүүд ээ.

15-12 гишүүн дэмжиж, 80 хувиар өөрчлөх нь зүйтэй гэж гишүүд маань үзлээ. Ингээд зарчмын зөрүүтэй саналаар санал хураая.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

4.1.16.Хөдөлмөрийн эрхийн маргаан гэж хөдөлмөрийн хууль тогтоомж, бүх төрлийн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хэрэгжүүлэх, эсхүл эдгээр хэм хэмжээг тайлбарлахтай холбоотойгоор талуудын хооронд үүссэн саналын зөрүүг.

Дэмжье гэсэн горимоор санал хураая.

15-13, 86.7 хувиар дэмжих нь зүйтэй гэж үзлээ.

3.Хөдөлмөрийн харилцаанд шударга бус үйлдлийг хориглохтой холбоотой. 11 дүгээр зүйлд “ажилтны төлөөлөгчид”-ийн дараа “ажилтан” гэдэг гол үгээ орхигдуулсан байна. Тиймээс үүнийг нэмэх шаардлагатай гэж үзсэн байгаа. Энэ саналыг дахин хураах шаардлагатай гэдгээр санал хураалт явуулъя гуравны хоёр нь дэмжих ёстой.

Санал хураалт

15-12 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ. Ингэснээр зарчмын зөрүүтэй санал хураалт явуулъя.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “ажилтны төлөөлөгчид” гэсний өмнө ажилтан гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн хэсгийн “зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “ажил олгогч” гэж тус тус нэмэх.

Санал хураалт гишүүд ээ. 15-11 гишүүн дэмжиж, 73.3 хувийн саналаар өөрчлөх нь зүйтэй гэж үзсэн учраас.

4.Ажил хаялт, хөдөлмөрийн эрхийн маргааныг дахиж томъёолсонтой холбогдуулаад төслийн 30.2 дахь хэсгийн “сонирхлын” гэдгийг хасах шаардлага үүсэж байгаа. Тиймээс 30.2 дахь хэсгийг дахин санал хураалгая гэдгээр санал хураалт. Гуравны хоёр нь дэмжих ёстой.

Санал хураалт

15-13, 86.7 хувиар гишүүд маань дэмжлээ. Тиймээс зарчмын зөрүүтэй санал одоо хураалгая.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “сонирхлын” гэснийг хасах.

Санал хураалт

15-13, 86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажил олгогч нь ажилтныг мэргэжлээ дээшлүүлэх, давтан сургах боломжоор хангах үүргийг хүлээлгэсэн. Үүнийг “ажлын байрны чиг үүргийн дагуу” гэж тодотгож өгөх нь зүйтэй гэж ажлын хэсэг үзсэн. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар гишүүний гаргасан санал байгаа. Тиймээс тухайн саналыг дахин санал хураалгая гэдгээр санал хураалт явуулна. Гуравны хоёр нь дэмжих ёстой.

Санал хураалт

15-13, 86.7 хувиар Ганбаатар гишүүний санал дэмжигдлээ. Ингэснээр зарчмын зөрүүтэй санал хураалгая.

Санал хураалт гишүүд ээ.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 43 дугаар зүйлийн 43.2-ын 9 дэх заалтын “хууль тогтоомжид заасны дагуу” гэсний дараа “ажлын байрны чиг үүрэгт хамаарах чиглэлээр” гэж нэмэх.

Санал хураалт

15-11, санал дэмжигдлээ.

6.Одоо бид нарын энэ хураалгах гэж байгаа санал нь хуулийн төслийн бусад заалттай нийцүүлж нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг ажил олгогч болон даатгуулагчаас төлөх гэж тодотгож байгаа. Энэ саналыг дахин хураалгах нь зүйтэй гэдгээр санал хураалт.

15 гишүүнээс 13 дэмжиж, 86.7 хувийн саналаар дэмжигдлээ. Ингээд зарчмын зөрүүтэй санал хураалт.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсгийн “Дагалдангаар суралцах ажилтны” гэсний дараа “ажил олгогчоос болон ажилтнаас төлөх” гэж нэмэх.

Санал хураалт

15 гишүүнээс 11 дэмжиж, 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.67.1-д давхардсан утга бүхий үг хасах шинжтэй, засвар хийсэн. Энэ саналыг дахиж хураалгах нь зүйтэй гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт

15 гишүүнээс 13 дэмжиж, 86.7 хувийн саналаар дэмжигдлээ хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингэснээр зарчмын зөрүүтэй санал хураалт явуулъя.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг хасах.

Санал хураалт. Техникийн саатал явчихлаа. Чинзориг гишүүн горимын санал гаргах уу? Чинбүрэн гишүүн үг хэлье.

Ж.Чинбүрэн: Миний iPad сая ажилласангүй, дараад байхад гарсангүй. Энийг цуцалж, дахин санал хураалт хийж өгнө үү.

М.Оюунчимэг: Чинбүрэн гишүүнд баярлалаа. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэдгээр Чинбүрэн гишүүний гаргасан саналыг дэмжье гэдэг горимоор санал хураалт.

Чинбүрэн гишүүний гаргасан санал дэмжигдлээ, 86.7 хувиар.

Дахин санал хураалт явуулъя. Би уншаад танилцуулчихъя.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг хасах.

Санал хураалт

15 гишүүнээс 13 дэмжиж, 86.7 хувийн саналаар дэмжигдлээ хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн далан 72.3-т найруулгын шинжтэй засвар хийсэн байгаа. Энэ саналыг дахиж хураалгах нь зүйтэй гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт

15-12 гишүүн дэмжиж, 80 хувийн саналаар дэмжигдлээ хувийн саналаар санал дэмжигдлээ. Ингэснээр зарчмын зөрүүтэй санал хураалга.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “үйлчлэх хугацаа” гэсний дараа “хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсноос хойш” гэж нэмэх. Энэ бас Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар нарын гишүүдийн гаргасан санал явж байгаа шүү.

Дэмжье гэдгээр санал хураалт

15 гишүүнээс 13 дэмжиж, 86.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Туршилтаар, дагалдангаар ажиллах, суралцаж буй ажилтан нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаагаа цуцлахдаа бусад ажилтны нэгэн адил ажил олгогчид мэдэгдэх үүргийг хүлээх нь зүйтэй гэж үзсэн учир төслийн 79.4 дэх хэсгийг хасах нь зүйтэй гэж ажлын хэсэг дээр хэлэлцсэн. Ж.Ганбаатар гишүүний гаргасан санал байгаа. Иймээс дахин санал хураалт явуулъя гэдгээр санал хураалт.

15-14 гишүүн дэмжиж, 93.3 хувийн саналаар санал дэмжигдсэн учраас зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх хэсгийг хасах.

Санал хураалт

15-14 гишүүн дэмжиж, 93.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 80 дугаар зүйл дээр техникийн шинжтэй засвар байгаа. Ажлын хэсгээс дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. Иймд дахин санал хураалт явуулахыг дэмжье гэдэг горимоор санал хураалт.

15-12 гишүүн дэмжиж, 80 хувиар энэ санал дэмжигдсэн учраас зарчмын зөрүүтэй санал хураалгая.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг” гэсний дараа “энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр” гэж нэмэх.

Санал хураалт

15-13 гишүүн дэмжиж, 86.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсэг дээр ажилтан нь ажлаа хүлээлгэн өгөх хүртэл хугацааны цалинг ажил олгогчоос авахаар оруулсан байгаа нь ажилтан өөрөө заасан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөлгүйгээр хугацааг сунгаад илүү хугацааны цалинг авах боломж үүсгэж байгааг харгалзан, төслийн 83.3-т заасан “ажил олгогч ажлаа хүлээлгэн өгөх хугацаа хүртэл” гэж тодорхой заахаар болсон. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар нарын гишүүдийн гаргасан санал байгаа.

Иймд санал хураалтыг дахин явуулъя гэдэг горимоор санал хураалт явуулъя.

15 гишүүн оролцсоноос 14 дэмжиж, 93.3 хувийн саналаар дэмжигдсэн учраас зарчмын зөрүүтэй санал хураалгая.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн төслийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83.5.Ажилтанд энэ хуулийн 83.3-т заасан хугацааны цалин хөлсийг ажил олгогч тооцож олгоно.”

Санал хураалт

14 гишүүнээс 14 дэмжиж, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 12 дугаар зүйл дээр техникийн шинжтэй засвар байгаа. Ажлын хэсгээс дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. Иймд дахин санал санал хураалт явуулахыг дэмжье гэдэг горимоор санал хураалт.

14-14, 100 хувиар санал дэмжигдлээ. Тиймээс зарчмын зөрүүтэй санал хураалгая.

Санал хураалт

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсгийн “ажлын байранд” гэснийг хасах.

Санал хураалт

14-13 гишүүн дэмжиж, 92.9 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 92.5 дугаар саналд найруулгын шинжтэй засвар хийж байгаа, өөрчлөн найруулсан. “Ажилтны ажил, амрах хугацааг ажил олгогч, ажилтан хамтын хэлэлцээрээр тохиролцож болно.” гэснийг заавал хамтын хэлэлцээр хийлгүйгээр хоорондоо харилцан тохиролцож болно гэдэг санал орж ирж байгаа.

Төслийн 92.5 дахь хэсгээр дахин санал хураалгая гэсэн саналыг дэмжье гэсэн горимоор санал хураалт.

14-14, 100 хувиар санал дэмжигдсэн учраас зарчмын зөрүүтэй санал хураалгая.

13.Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“92.5.Энэ хуулийн 92.4-т заасан хугацааг багасгах тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх, амрах хугацаа нь тэнцүү байхаар ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцож болно.”

Санал хураалт, дэмжье гэдэг горимоор.

14-12, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 14 дүгээр зүйл дээрх техникийн шинжтэй засвар байгаа. Ажлын хэсгээс дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэж байгаа учраас дахин санал хураалтыг дэмжье гэдгээр санал хураалт.

Гишүүдийн гуравны хоёр нь буюу 85.7 хувь нь дэмжсэн учраас зарчмын зөрүүтэй санал хураалгая.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 104 дүгээр зүйлийн 104.7 дахь хэсгийн “олгоогүй, эсхүл” гэснийг хасах.

Санал хураалт

92.9 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 15 дугаар зүйл дээр бас техникийн шинжтэй засвар байгаа учраас ажлын хэсгээс дахин хураалгах шаардлагатай гэж үзсэн. Иймд дахин санал хураалт явуулахыг дэмжье гэдэг горимоор санал хураалт.

14-13, 92.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тиймээс зарчмын зөрүүтэй санал хураалгая.

Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 107 дугаар зүйлийн 107.2 дахь хэсгийн “хамтын хэлэлцээрээр зохицуулна.” гэснийг “хамтын хэлэлцээрээр зохицуулж болно.” гэж өөрчлөх.

Санал хураалт

14-14, 100 хувиар санал дэмжигдлээ.

Өмнөх санал хураалтад Бейсен гишүүн бүгд дэмжиж, протоколд тусгаарай гэж байна шүү. Аппаратыг нь засаад өгөөрэй.

16.Төслийн 123 дугаар зүйл дээр өгүүлбэр давхацсан байгаа. Тиймээс нэг илүү давхацсан агуулга бүхий өгүүлбэрийг хасах техникийн шинжтэй засвар байгаа учраас ажлын хэсгээс дахин санал хураалтыг явуулж өгнө үү гэсэн байгаа. Иймээс санал хураалтыг дахин явуулъя гэдэг горимоор санал хураалт.

14-14, 100 хувиар санал дэмжигдлээ. Ингэснээр зарчмын зөрүүтэй санал хураалгая.

16.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн төслийн 123 дугаар зүйлийн 123.7 дахь хэсгийн “Ажил олгогч, сахилгын зөрчлийн шинж үр дагаврыг харгалзан энэ хуулийн 114.1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэнэ.” гэсэн хоёр дахь өгүүлбэрийг хасах.

Санал хураалт

14-14, 100 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 17 дугаар зүйл дээр техникийн шинжтэй засвар байгаа. Ажлын хэсгээс мөн дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн учраас дахин санал хураалтыг дэмжье гэдэг горимоор санал хураалт

100 хувь гишүүд маань дэмжсэн учраас зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

17.Анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 154 дүгээр зүйлийн 154.11 нэг дэх хэсгийн “эсхүл шийдвэрийг” гэснийг “эсхүл шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш” гэж өөрчилж мөн хэсгийн “хүлээн авснаас хойш” гэснийг хасах.

Санал хураалт

14-14, 100 хувиар санал дэмжигдлээ.

18.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх хугацааг ажлын хэсэг дээр ярилцаад 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдөхөөр тогтсон. Энэ саналыг дэмжиж хураалгая гэдгээр Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёр нь дэмжих байгаа. Ингээд дэмжье гэдгээр санал хураалт.

14-14, 100 хувиар санал дэмжигдлээ. Ингэснээрээ зарчмын зөрүүтэй санал хураалгая.

18.Төслийн 166 дугаар зүйлийг 166.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

Энэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт

14-14

Хамгийн сүүлийн санал хураалт

19.Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь шинэчлэгдэн батлагдсан бөгөөд энэ хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй тул хууль

санаачлагчид буцаахаар болсон байгаа. Тэгэхээр Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт

14-14, 100 хувиар энэ санал дэмжигдлээ.

Санал хурааж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Сарангэрэл нарын гишүүдээс амралт ажилтай холбоотой санал гаргасан байгаа. Энэ саналыг ажлын хэсгийн ахлагчид танилцуулах уу? Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Сарангэрэл нараас Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсгийн “ажлын хорин өдөр” гэснийг “ажлын арван таван өдөр” гэж өөрчлөөд, хуулийн төслийг өргөн барихад байсан зохицуулалт буюу жилийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр, тэгээд ажилласан жилээсээ шалтгаалаад нэмэлт өдрүүдийг нэмээд тусгая, энэнтэйгээ хамт Төрийн албаны хууль бусад хуулиудад 20 өдөр болгосонтой холбогдуулж оруулсан өөрчлөлтүүдийг буцаагаад хэвийн байдалд нь оруулъя, одоогийнхонд нь оруулъя гэсэн санал ирүүлсэн юм. Тэгээд энэ саналаар санал хураалгаж өгөхийг хүсэж байна.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагч баярлалаа. Тэгэхээр саяын Сандаг-Очир, Сарангэрэл нарын гишүүдийн гаргасан саналыг дахин санал хураалгах нь зүйтэй гэж гэдгээр горимын санал хураалт явуулъя. Гуравны хоёр нь дэмжсэн тохиолдолд зарчмын зөрүүтэй саналыг хураалгахаар байгаа.

Санал хураалт, дэмжье гэдэг горимоор.

14-13, 92.9 хувийн саналаар дээрх гишүүдийн санал дэмжигдлээ. Ингэснээр зарчмын зөрүүтэй санал хураалгахаар байгаа. Санал хураалт явуулъя.

Саналын томъёолол

1.Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсгийн “ажлын 20 өдөр” гэснийг “ажлын 15 өдөр” гэж өөрчлөх.

Дэмжье гэдэг горимоор санал хураалт

14-12, 85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн 99 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“99 дүгээр зүйл.Ээлжийн амралт, түүний хугацаа

99.1.Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.

99.2.Ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш 6 сар ажилласан бол түүнд ээлжийн амралт эдлэх эрх үүснэ.

99.3.Хуульд өөрөөр заагаагүй бол ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 15 өдөр байна.

99.4.Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна.

99.5.Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дор дурдсан нэмэгдэл амралт олгоно.

99.5.1.Зургаа дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 3 өдөр;

99.5.2. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 5 өдөр;

99.5.3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 7 өдөр;

99.5.4. 21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 9 өдөр;

99.5.5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуустал хугацаанд ажлын 11 өдөр;

99.5.6. 32 дахь жилээс ажлын 14 өдөр.

99.6.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дор дурдсан нэмэгдэл амралтыг олгоно:

99.6.1. 6 дахь жилийн эхнээс 10 дахь хэсгийг дуустал хугацаанд ажлын 5 өдөр;

99.6.2. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 7 өдөр;

99.6.3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 9 өдөр;

99.6.4. 21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуустал хугацаанд ажлын 12 өдөр;

99.6.5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуустал хугацаанд ажлын 15 өдөр;

99.6.6. 32 дахь жилээс ажлын 18 өдөр.

99.7.Ажлын бүтэн бус цагийн ажилтан тухайн ажлын жилд нийт ажилласан цагийг нь тооцож ногдох ээлжийн үндсэн болон нэмэгдэл амралт олгоно.

99.8.Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг нь тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна.

99.9.Ажил, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл амралтын хугацааг холбогдох хуулиар тогтоож болно.

99.10.Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

М.Оюунчимэг: Мөнх-Оргил гишүүн санал хэлье.

Ц.Мөнх-Оргил: Сандаг-Очир /Чинзориг/, Сарангэрэл гишүүдийн санал дэмжигдсэнтэй холбогдуулаад манай ажлын албаныхан 99 дүгээр зүйлийг бүхэлд нь шинэчлэн найруулъя гээд байгаа юм байна л даа. Тэгж хэрэггүй ээ. Одоо хэдүүлээ саналаа хураахдаа бүх өдрүүдээ зүгээр 20-ийг 15 болгоод л, 99.4 дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амралт чинь 25 нь буцаад 20 болж байгаа байхгүй юу. Тэгээд л энэнийхээ ард 99.4-ийн ард 99.5 дугаар зүйлд дараах зүйл нэмсүгэй гээд санал хураалгаад, саяын уншсаныг оруулаад, араас нь 99.6 гээд хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийн нэмэлт амралтын өдрүүдийг нэмж оруулаад. Тэгээд бусад бүх юм нь үндсэндээ хэвээрээ л байна шүү дээ. Хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажлын нэмэгдэл амралт байж байна. Бусад хэсэгчлэн амралтын гээд бусад бүх юм нь бүгдээрээ байж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ингэж бүхэлд нь шинэчилж найруулаад хэрэггүй. Тэгээд л санал хураачихъя, тэгэх үү, дарга аа? Таны саяын уншсан, тэгэхдээ миний горимын саналыг тусгаад одоо санал хураачхаад ажлын албаныхан янзлаг.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүний саяын гаргасан саналыг дэмжье гэж бодож байна. Яагаад гэвэл угаасаа одоо үйлчилж байгаа Хөдөлмөрийн хуульд саяын уншсан ихэнх заалтууд байгаа. Эндээс саяын хэлж байгаа 99.4, 99.6 өөрчлөгдөж байгаа. Бусад нь бол яг хуучнаар явж байгаа учраас горимын саналаар дэмжье гээд санал хураалт явуулъя.

Харин нэгдсэн чуулганд танилцуулахдаа манай ажлын хэсэг найруулгын засвараа хийчхээрэй.

Ингээд саяын санал хураалтыг дэмжье гэдэг горимоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

14-13, 92.9 хувийн саналаар Сандаг-Очир, Сарангэрэл нарын гишүүдийн гаргасан санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “Төрийн албан хаагчид олгох, ээлжийн нэмэгдэл амралт” гэсэн 61¹ дүгээр зүйлийг хасах.

Дэмжье гэдэг горимоор санал хураалт.

14-14, 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүн санал хэлье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Байнгын хорооны гишүүд, байнгын хорооны дарга, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Шинэчилсэн найруулгын нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж эцсийн хэлэлцүүлгээр санал хураасан учраас одоо би

Байнгын хорооны даргыг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн зарим хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөөр санал хураалгаад өгөөч гэсэн хүсэлттэй байгаа. Энэ бол агуулга ерөөсөө байхгүй, зөвхөн эшлэлүүд өөрчлөгдсөн. Тэгээд одоо бид нарын баталж байгаа энэ хуулийн шинэчилсэн найруулгын 65 дугаар зүйлд “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” гээд. Би танилцуулж байгаа юм, тэгвэл ойлголоо.

М.Оюунчимэг: Сая ажлын хэсгийн ахлагч хэллээ. Бид нар энэ гишүүдэд бас тараасан материал дээр байгаа. Энэтэй холбоотой зарим нэгэн дагалдах хуулиудаар санал хураалгах байгаа. Эндээ одоо оръё.

Бид нар чухал гол саналуудаа хурааж дууссан учраас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн хэлэлцүүлгийг хийж дууссан.

Тиймээс чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргилыг томилъё.

Дараагийн асуудал.

Одоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.5-д заасны дагуу хууль, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэн баталж болно гэж заасны дагуу ажлын хэсгээс Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол, Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан байгаа. Энэ Хөдөлмөрийн хуулийг ишилсэн таван хуулийн анхны хэлэлцүүлэг байгаа.

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

4. Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай

5. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гэсэн энэ хуулиуд байгаа.

Хөдөлмөрийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол хөдөлмөрийн тухай энэ шинэ найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа.

Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хамтын гэрээ, улс, нийслэл, аймаг, сум, дүүрэг, салбар, салбар дундын хамтын хэлэлцээрийг тухайн хамтын гэрээ, хэлэлцээрээр тохиролцсон хугацаанд дагаж мөрдөнө. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан хамтын гэрээ, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн гэрээг талуудын харилцан тохиролцсон хугацаагаар дагаж мөрдөнө. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн хөдөлмөрийн гэрээнд ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн ажилтны эрх зүйн байдал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг дордуулахгүй байх зарчмыг баримтална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Чинзориг гишүүн танхимд байна. Чинзориг гишүүнээр тасалъя. Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Мөнх-Оргил гишүүн ээ, энэ Журмын тухай хуулийг зарчмын хувьд бол дэмжиж байна. 2 дугаар зүйл дээр зарчим баримтална гээд байх юм. Тэрийгээ зарчим баримтална гэх юм уу, ерөөсөө хөдөлмөр эрхлэлтийн ажилтны эрх зүйн байдал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг дордуулахгүй байна гээд ингээд шууд хэлчих л хэрэгтэй л дээ. Тэгэхгүй бол зарчим баримтална гэхээр, цаадуул чинь зарчим баримталсан янз янзын юм хийчихвэл. Би бол шууд дордуулахгүй байна гээд ингээд л оруулчихмаар байх юм. Тэр найруулгаар авчихвал болох уу?

М.Оюунчимэг: Таны хэлснээр 2 дугаар зүйл дээр хөдөлмөрийн гэрээг талуудын харилцан тохиролцсон хугацаагаар дагаж мөрдөнө. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн хөдөлмөрийн гэрээнд ажил олгогч ажилтан харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн ажилтны эрх зүйн байдал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг дордуулахгүй байна гээд найруулгын өөрчлөлт хийчихье.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ хуулийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргаж байна. Даргаа, горимын саналаар санал хураалгаж өгөхийг хүсэж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргилын зүгээс анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдэг горимын санал гаргаж байна. Энэ саналыг дэмжье гэдэг горимоор санал хураалт явуулъя.

Дэмжье гэдгээр санал хураалт

14-12, 85.7 хувийн саналаар дэмжигдсэн учраас анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасгай.

1/Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найруулгад нийцүүлэн Эрүүгийн, Иргэний, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганы хуралдаанд хугацаанд, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 онд багтаан Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлэх;

2/сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог байгуулж, хорооны гишүүд, хөдөлмөрийн зуучлагч арбитрчдыг бэлтгэх, чадавхжуулах;

3/Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг ажил олгогч, ажилтан, олон нийтэд тайлбарлан таниулах ажлыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллага, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран үе шаттай зохион байгуулах;

4/Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын хэрэгжилтийг хангахад шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Оюунчимэг/-нд даалгасгай.

Мөнх-Оргил гишүүн, дараа нь Чинзориг гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Тогтоолын төслийн 1.2 дахь заалт буюу сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог байгуулж, хорооны гишүүд хөдөлмөрийн зурагт арбитрчдыг бэлтгэх, чадавхжуулах ажлыг ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтарч энэ ажлыг зохион байгуулахыг үүрэг болгох нь зүйтэй байх. Яагаад гэвэл энэ арбитрчдыг бэлтгэх асуудал бол зөвхөн Засгийн газраас гадна энэ ажил олгогчид, үйлдвэрчний эвлэл ч гэсэн бас хамтарч сургалтад нь оролцох, сонгон зохион байгуулах ажилд оролцоод явж байх нь зөв байх аа.

М.Оюунчимэг: Мөнх-Оргил гишүүний гаргасан саналаар сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороог байгуулж, хорооны гишүүд, хөдөлмөрийн зуучлагч, арбитрчдыг бэлтгэх, чадавхжуулах ажлыг ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран зохион байгуулах гэж найруулъя.

Чинзориг гишүүн үг хэлье.

С.Чинзориг: Тогтоолын төслийг бол дэмжиж байна. Товчхон л тогтоолын төсөл болж дээ. Одоо яах вэ дээ. 1.3 дээр ийм санал байгаа юм. Хөдөлмөрийн тухай хуулийг ажил олгогч, ажилтан, олон нийтэд тайлбарлан таниулах ажлыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллага, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран үе шаттайгаар зохион байгуулах гээд. Би тэр тайлбарлан тайлбарлан таниулах гэдгийг бол сурталчлах гэсэн юугаар жаахан найруулах юм уу? Сурталчлах гээд, таниулах гэж үг хэлээд яах вэ. Сурталчлах гэсэн юугаар жаахан найруулмаар байна.

Хоёрдугаарт, ажил олгогч, ажилтны эрх ашгийг хууль ёсны ажил олгогч, ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллага гэдгийгээ би энэ гурвыг адилтган авч үзээд Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын Ажил олгох эздийн холбоо, Монголын Үндэсний Худалдаа, аж зүйн танхим гээд адилхан нэрээр нь биччихмээр байна. Тэгэхгүй бол нэгийг нь writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

товойлгоод, нөгөө хоёрыг нь үндэсний байгууллага гээд байгаа юм уу, үгүй бол үндэсний байгууллага нь Худалдаа, аж үйлдвэрийн танхим ч юм уу. Одоо тэр гурав чинь гараад л хэрэлдэнэ шүү дээ. Би мэдэж байна.

Тийм учраас энэ төлөөлөн хамгаалах үндэсний байгууллага Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай гээд адилхан нэрээр нь биччихвэл, найруулгаар. Үгүй бол төлөөлөн байгууллага гэж шууд биччихвэл. Тэгэхгүй бол энэ гурав чинь одоо гараад л маргалдана би мэдэж байна.

М.Оюунчимэг: Чинзориг гишүүний гаргасан саналын дагуу 3 дахь хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг ажил олгогч, ажилтан, олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлын байгууллагууд болох Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо.

Гурав дахь найруулга дээр манайхан анхаараад засах нь байна шүү дээ. Шууд Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг ажил олгогч, ажилтан, олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран үе шаттай зохион байгуулах гэх маягаар оруулах нь байна шүү дээ. Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулах гээд найруулга дээр засаарай.

Мөнх-Оргил гишүүн санал хэлье.

Ц.Мөнх-Оргил: Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргаж байна.

М.Оюунчимэг: Мөнх-Оргил гишүүний гаргасан саналын дагуу анхны хэлэлцүүлгээр нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэдэг горимыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт эхлээд явуулчих уу? Гишүүд ээ, санал хураалт шууд явуулчихъя.

Дэмжье гэдгээр санал хураалт. Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас.

14-11, 78.6 хувийн саналаар анхны хэлэлцүүлгээр нь батлах санал дэмжигдлээ. Протоколд тэмдэглэхэд зарчмын зөрүүтэй өөр санал гараагүй учраас санал гаргасан гишүүний саналыг шууд хураалгаад байгаа шүү гэдгийг бас тэмдэглэе, найруулгаар нь аваад.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан таван хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Түрүүн би уншиж танилцуулсан, ишилсэн таван хуулийн төсөл байгаа.

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтын “контракт” гэснийг “онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэнтэй холбоотой асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна уу? Горимын санал Мөнх-Оргил гишүүн хэлье.

Ц.Мөнх-Оргил: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналтай байна.

М.Оюунчимэг: Өөр зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас сая Мөнх-Оргил гишүүний гаргасан анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Эцэслэн батлах. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулахыг.

Санал хураалт

14-12, 85.7 хувийн саналаар анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн баталъя гэдэг санал дэмжигдлээ.

2.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “контракттай” гэснийг “онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээтэй” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэнтэй холбоотой асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна Мөнх-Оргил гишүүн горимын санал гаргая.

Ц.Мөнх-Оргил: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналтай байна.

М.Оюунчимэг: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагчийн гаргасан горимын саналын дагуу анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдэг саналыг дэмжье гэдэг горимоор санал хураалт.

Санал хураалт

Ц.Мөнх-Оргил: Сая мөн үү?

М.Оюунчимэг: 14-11, 78.6 хувийн саналаар анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн баталъя гэдэг санал дэмжигдлээ.

Уучлаарай, энд дахиад санал гарч байгаа учраас санал хураалт цуцлагдлаа. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Уучлаарай, Байнгын хорооны дарга аа, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналтай байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн, ажлын ахлагчийн гаргасан горимын саналаас өөр зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа учраас Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн

төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдэг саналыг дэмжье гэдгээр санал хураалт.

14-10, 71.4 хувийн саналаар анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн санал дэмжигдлээ.

Дараагийн хууль

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2.3 дахь заалтын “контракт” гэснийг “онцгой нөхцөл байдал, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “контрактад” гэснийг “онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Найруулгын шинжтэй ийм өөрчлөлт байгаа

Мөнх-Оргил гишүүн санал гаргах уу? Асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал бас нэрээ өгнө үү.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Саяын хуулийг анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналтай байна, дарга аа.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагчийн гаргасан горимын саналаас өөр зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас саяын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн саналыг дэмжье гэдгээр санал хураалт.

14-11, 78.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдэг.

Дараагийнх

Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “106.1”-д гэснийг “139.1”-д гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэнтэй асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгатай хамт баталсантай батлагдахтай холбогдуулж Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналтай байна.

М.Оюунчимэг: Мөнх-Оргил гишүүний гаргасан горимын саналаар анхны хэлэлцүүлгээр нь энэ хуулийн төслийг баталъя гэдгийг дэмжье гэдгээр санал хураалт

14-13, 92.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.6.6 дахь заалтын “63.2-т” гэснийг 119.2-т гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэнтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Мөнх-Оргил гишүүн санал гаргая.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ хуулийг анхны хэлэлцүүлгээр баталъя аа гэсэн горимын саналтай байна. Санал хураалгаж өгөхийг хүсэж байна.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүний гаргасан саналаар анхны хэлэлцүүлгийг нь эцэслэн баталъя гэдгээр санал хураалт явуулъя.

Дэмжье гэдэг горимоор.

14-12, 85.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явуулж дууслаа. Санал хураалтдаа идэвхтэй оролцож байгаа гишүүддээ баярлалаа.

Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хөдөлмөрийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг хийсэн. Мөн Байнгын хороогоор, удахгүй нэгдсэн хуралдаанаар ч гэсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэх гэж байгаатай холбогдуулаад “Оюу толгой” ХХК-аас энэ хуульд долоон өөрчлөлт оруулж өгөөч ээ, ийм саналууд байна гэсэн хүсэлт ирүүлсэн юм. Тэгээд эдгээр хүсэлтийг бид нар ажлын хэсгийн хуралдаан дээрээ дэлгэрэнгүй ярилцаад, долоон саналыг хүлээж авах бололцоогүй байна гэж үзсэн юм. Тэгээд энэ саналуудыг нь танилцуулаад үндэслэлийг нь би Байнгын хорооны протоколд оруулчихъя гэж бодож байна. Яагаад гэвэл энэ олон хүн ажиллуулдаг, манай Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн том гадаадын хөрөнгө оруулалттай компани учраас саналд нь хүндэтгэлтэй хандах ёстой гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт, хуулийн үйлчлэх хугацааг 2022 оны 1 сарын 1-ний өдрөөс биш 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс болгож өөрчилж өгөөч гэсэн санал ирүүлсэн юм. Энийг бид нар ажлын хэсэг дээр ярьж байгаад ер нь энэ хуулийн төслийг бэлтгэх, хэлэлцэх, хэлэлцүүлэг хийх явц бол сүүлийн есөн жил тасралтгүй хийгдсэн, олон талын зөвшилцөл, зөвшилцөл дээр суурилсан, гарах өөрчлөлтүүд нь бол техникийн шинж чанартай өөрчлөлтүүд учраас ажил олгогч нарт энэ хуулийг 2022 оны 1 сарын 1-нээс хэрэгжүүлээд явахад хүндрэл гарахгүй гэж үзсэн. Тэгээд гол ажил нь сурталчлан таниулах ажил Засгийн газар дээр ноогдож байгаа.

Хоёр дахь санал нь уртын ээлж болон ээлж гэдгийг тодорхой болгож ялгаж салгаж өгөөч гэсэн санал тавьсан юм. Тэгээд манай хуульд бол ээлж, уртын ээлж гэдэг хоёрыг бол аль аль нь тодорхойлолтой. Уртын хэлж бол ийм, ийм тохиолдолд ийм, ийм салбарт уртын ээлжээр ажиллуулна уртын ажиллах хугацаа нь, амрах хугацаа нь гээд маш дэлгэрэнгүй зохицуулалттай байгаа. Тийм учраас уртын ээлж ээлж хоёрыг хооронд нь бол будилж хутгах тийм аюул гарахгүй ээ. Уртын ээлжээр ажиллуулах тохиолдолд ажлын цагийг нэгтгэн бодох замаар илүү цагийг тооцох, ердийн ажлын өдрийн цагаас илүү ажилласан цагийг илүү цагаар тооцох зэрэг асуудлуудыг тодорхой тусгаж өгөөч гэсэн санал гаргасан. Энэ бол зөв санал. Гэхдээ бид одоо энэ хуулийнхаа төслөөр юу гэж заасан бэ гэхээр ажлын цагийг нэгтгэн бодох журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлахаар заасан байгаа. Тэр их нарийвчилсан техникийн зохицуулалт учраас тэнд түүгээрээ бол энэ саналууд нь тусгагдаад явчихна.

М.Оюунчимэг: Ажлын хэсгийн ахлагчид 1 минут нэмж өгье.

Ц.Мөнх-Оргил: Намайг ярьж дуустал битгий хаагаарай. Протоколд тэмдэглүүлж байгаа учраас.

Гуравт, бүх төрлийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг дундаж цалин хөлснөөс бус үндсэн цалингаар тооцож олгож өгөөч гэсэн санал ирүүлсэн юм. Энийг бид олон удаа ярьсан. Тэгээд бүх төрлийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг янз янзаар тооцож байгаа. Заримыг нь бол үндсэн цалингаар тооцож байгаа, зарим нь бол дундаж цалингаар тооцож байгаа. Гэхдээ онцолж хэлэхэд өмнө нь бол ихэнхдээ дундаж цалин хөлс дээр тооцож байсныг одоо бид нар тухайн нэмэгдэл нэмэгдэл хөлсийн шинж чанараас нь шалтгаалаад, зарим нь дундаж цалингаас зарим нь үндсэн цалингаас тодорхойлж байгаа.

Дөрөвт, хуулийн төсөлд шууд ажил хаяхыг хориглосон заалтууд байгаа ч гэсэн одоо энэ хуулийн заалтдаа ажил олгогч хуульд заасан хугацаанд хамтын хэлэлцээг эхлүүлээгүй тохиолдолд үйлдвэрчний эвлэл ажил хаялтыг зохион байгуулах эрхтэй гэсэн заалттай зөрчилдөж байна, энийг хасаач ээ гэсэн санал.

М.Оюунчимэг: Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Энийг бол хүлээж авах бололцоогүй юм. Ажил олгогч хамтын хэлэлцээг хуулиар заасан хугацаанд эхлүүлээгүй тохиолдолд үйлдвэрчний эвлэл бол ажил хаялтаа зохион байгуулах эрхтэй гэж үзэж байгаа.

Дараагийнх нь, ажил олгогч дотоод журмаа хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн батлуулах гэсэн шаардлагыг хасаач ээ гэсэн санал ирүүлсэн. Энийг хүлээж авах бололцоогүй. Яагаад гэвэл ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмаа өөрөө тогтоож байгаа. Гэхдээ дотоод журмаа тогтоохдоо хамтын гэрээ, хамтын хэлэлцээртээ нийцүүлэх ёстой. Хууль тогтоомжтой нийцүүлэх ёстой. Тэгэхгүй бол хамтын гэрээ хамтын хэлэлцээртэйгээ зөрчилдсөн хөдөлмөрийн дотоод журам батлуулж болохгүй.

Сүүлд нь, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн, удаан жил ажилласны, мэргэжлийн зэргийн гэх нэмэгдэл нэмэгдэл хөлсийг хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, бүгдэд нь нийцүүлэн тогтоохоор заасан. Үүний улмаас хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, гадаад болон дотоод хөрөнгө оруулагчдын аль алинд нь таагүй байж тэдгээрийг үргээхээр байна гэсэн санал ирүүлсэн байгаа. Тийм үргэх нөхцөл бол үүсэхгүй. Яагаад гэвэл хэвийн бус

нөхцөлийн, удаан жил ажилласан, мэргэжлийн зэргийн гэх бүх нэмэгдлүүд нь одоо байгаа хэмжээндээ байгаа. Энийг бол аль нь ч нэмээгүй.

Тэгээд эцэст нь, 7.Олон түвшинд хийгдсэн салбарын хамтын хэлэлцээрийг ажил олгогч болон тэдгээрийн төлөөлөгч заавал дагаж мөрдөхөөр байгаа. Зөвхөн салбарын хамтын хэлэлцээрийг үлдээж аймаг, сум, дүүргийн түвшний хамтын хэлэлцээрийг хасаж өгөөч ээ гэсэн санал ирүүлсэн байгаа. Яагаад гэвэл одоогоор практик дээр ийм гэрээнүүд алга гэсэн санал ирсэн байгаа юм. Тэгээд практик дээр ийм гэрээ цөөхөн байгаа нь үнэн. Гэхдээ байгуулагдаад явах юм бол эдгээр гэрээгээ дагаж мөрдөх ёстой. Тэгээд энэ байгуулагдах аймаг, сум, дүүргийн гэрээнүүд нь бол Хөдөлмөрийн хууль тогтоомжтой нийцэж байгуулагдах ёстой учраас энд бол ажил олгогчдод сүрхий дарамт учруулсан зүйл гарахгүй гэж үзэж байгаа. Баярлалаа. Протоколд тэмдэглүүлж байгаа юм.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүнд баярлалаа. Ер нь Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Үйлдвэрчний эвлэл гээд тал талуудын яг энэ салбарынхны байр суурийг энэ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх явцдаа манай ажлын хэсгийнхэн маш сайн, анхааралтай асууж, байр суурийг нь сонсож, хэлэлцүүлгүүд хийсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайд хүртэл орж ирээд бас мэдээлэл хийе гээд, бид сонсож байсан. Сая Мөнх-Оргил гишүүн Оюу толгойн энэ том хөрөнгө оруулагч компанийн байр суурийг бас хэллээ.

Мэдээж Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх хууль тогтоомжийн хүрээнд бас Хөдөлмөрийн тухай хууль үйлчлэх учраас энийг бол харгалзаж энэ асуудлуудыг тал талын байр суурийг харж, ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал харж ингэж эцэслэж шийдэж байгаа гэдгийг бас дуулгачихъя гэж бодож байна.

Тэгээд Хөдөлмөрийн хууль /шинэчилсэн/ найруулга, түүнтэй дагаж батлагдах хуулийн төслүүдийг сая ингээд танилцуулж, бүгдээрээ эцсийн анхны хэлэлцүүлгээр нь батлахаар ингээд гишүүдийн олонх нь дэмжлээ.

Ингээд Байнгын хороонд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.5-д заасны дагуу хууль, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулж, анхны хэлэлцүүлгийг хийлээ. Анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд би өөрөө уншаад танилцуулчихъя.

Үүгээр бид Нийгмийн бодлогын байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудлын эхний асуудлаа хэлэлцэж дууслаа. Одоо Хөдөлмөрийн тухай хуулийнхаа энэ том хуулийн ард ямар ч байсан бид, Байнгын хороо маш амжилттай гарлаа. Гишүүд маань бас идэвхтэй оролцлоо.

Түрүүн Мөнх-Оргил гишүүн, ажлын хэсгийн ахлагч хэлж байна. Сүүлийн есөн жил дараалан нэр, гурван парламент, таван Засгийн газар дамжин яригдаж байсан Хөдөлмөрийн тухай хуулийг бид ийнхүү үнэхээр гурван талт түншлэлийн үндсэн дээр харилцан ойлголцож байж, бүх бололцоотой энэ хөдөлмөрийн зах зээлийн харилцааг зохицуулах, бүх заалтуудыг удаан хугацаанд энэ хууль тогтвортой үйлчлэх ийм хэмжээнд ямар ч байсан боловсруулж энэ Улсын Их Хурал маань одоо ингээд эцэслэн батлах гэж байна. Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн хэлэлцүүлэг, дагалдах

хуулиудын анхны хэлэлцүүлгийг хийхэд идэвхтэй оролцсон эрхэм гишүүддээ баярлалаа.

Ингээд хоёр дахь хэлэлцэх асуудалдаа оръё.